



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 8/550

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дах заалт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, “Орбис интернэйшнл” ашгийн бус корпораци хооронд 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр байгуулсан “Төсөл хэрэгжүүлэх түншлэлийн гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



Эрүүл мэндийн сайдын
2019 оны **Н**-ны едрийн
дугаар тушаалын хавсралт
Ний

**МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТИЙН НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА**

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажилласан байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний серий/дугаар	Төрөлжсөн мэргэшшийн чиглэл	Зөвшөөрлийн терөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Чан Робисон Вернон Паул	Америкийн Нэгдсэн Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	“Орбис интернэйшнл” ашгийн бус корпораци	ГЭ0002491	Нудчий мэс засал судлал	Эмчлэх 2019.12.09-2019.12.15 /7 хоног/	